



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
12 -Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 15

Эрдэнэ-Уул

「2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг
санхүүжүүлэх зориулалтад өөрчлөлт
оруулах тухай

Сумын 2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд өөрчлөлт оруулах тухай сумын Санхүү албаны дарга П.Гантуяагийн мэдээлэл, өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцээд Монгол Улсын “Төсвийн тухай хууль”-ийн 64.1.2, “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 48 дүгээр зүйлийн 48.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ нь:**

Сумын 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

Нэг. Сумын орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 184,822,9 мянган төгрөгөөр тогтоосугай.

Хоёр. Малын тоо толгойн албан татвараас санхүүжих орлогын шилжүүлэг 90,000,0 сая төгрөгөөр тогтоосугай

Гурав. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 10,800,0 мянган төгрөг


Дөрөв. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ жагсаалтыг, нэгдүгээр хавсралтаар, Орон нутгийн

хөгжлийн сангийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

Тав. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын төрийн захиргаа, төсөв санхүүгийн хороонд үүрэг болгосугай

Зургаа. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12-р сарын 15-ны өдрийн 39 дугаар тогтоолын 3,4-р хавсралтыг хүчингүйд тооцсугай

ДАРГА



Т. БААСАНСҮРЭН


Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2022 оны 05 дугаар сарын 27 ны өдрийн 15
 тоот
 тогтоолын 1-р хавсралт

Сэргэлэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

(мянган төгрөг)

| д/д | Төсөл арга хэмжээний нэр | Хамрах салбар | Эхлэх/ дуусах хугацаа | төсөвт өртөг | 2022 онд санхүүжүүлэх дүн |
|--|--|---------------|-----------------------|------------------|---------------------------|
| 1. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт | | | | | |
| 1.1 | Гэрэлтүүлгийн урсгал засвар / БХөрөнгө / | Нийгмийн | 2022-2022 | 4,000,0 | 4,000,0 |
| 1.2 | 1,4-р багийн төвийн гэрэлтүүлэг / ТТөхөөрөмж / | Нийгмийн | 2022-2022 | 40,000,0 | 40,000,0 |
| 1.3 | Гудамж төсөл-тохижолт/ БХөрөнгө / | Нийгмийн | 2022-2022 | 70,822,9 | 70,822,9 |
| 1.4 | Ахуй үйлчилгээний барилга /ББайгууламж/ | Нийгмийн | 2022-2022 | 60,000,0 | 60,000,0 |
| 1.5 | Худгийн цахим төхөөрөмж / ТТөхөөрөмж / | Нийгмийн | 2021-2022 | 10,000,0 | 10,000,0 |
| | Дүн | | | | 184,822,9 |
| 2.Малын тоо толгойн албан татварын 2022 оны орлогоос санхүүжүүлэх | | | | | |
| 2.1 | Мал ээмэгжүүлэхэд / БХөрөнгө / | ХАА | 2022-2022 | 10,000,0 | 10,000,0 |
| 2.2 | Гар аргаар алт олборлосон газрыг хамгаалах | Байгаль орчин | 2022-2022 | 30,000,0 | 30,000,0 |
| 2.2 | Шувууны суултуур / БХөрөнгө / | Байгаль орчин | 2022-2022 | 15,000,0 | 15,000,0 |
| 2.3 | Байгаль орчин нөхөн сэргээхэд / БХөрөнгө / | ХАА | 2022-2022 | 5,000,0 | 5,000,0 |
| 2.4 | Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх /БХөрөнгө/ | ХАА | 2022-2022 | 30,000,0 | 30,000,0 |
| | Дүн | | | | 90,000,0 |
| | Нийт дүн | | | 274,822,9 | 274,822,9 |

Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 3 дугаар сарын 27 ны өдрийн 15 тоот
тогтоолын 2-р хавсралт



**Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 2022 оны төсвийн жилд
хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

| д/д | Төсөл арга хэмжээний нэр | Хамрах салбар | Эхлэх/дуусах хугацаа | Төсөвт өртөг | 2022 онд санхүүжүүлэх дүн |
|-----|---|---------------|----------------------|--------------|---------------------------|
| 1 | Наадмын талбайн үлдэгдэл / ББайгууламж/ | нийгмийн | 2022-2022 | 9,900,0 | 9,900,0 |
| 2 | Гэрэлтүүлгийн урсгал засвар / БХөрөнгө / | Нийгмийн | 2022-2022 | 900,0 | 900,0 |
| | Нийт дүн | | | 10,800,0 | 10,800,0 |